| АПУ ХК-ийн 2026 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/ | |
|---|---|
| *Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.* | |
| | |
| *Тайлагнах хугацаа* | 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийнгэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | Нэр: АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ<br>УБГД: 000165753, РД: 2702673<br>ҮЦКод: APU<br>Утас: 11-344336 |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | Монголын хөрөнгийн бирж |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | Шингэн хүнсний үйлдвэрлэл |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | 1,064,181,553 |
| *Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | Тайлагналын менежер Н.Мягмардорж,<br>Комплайнсын мэргэжилтэн Б.Мягмар,<br>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг |

1. *Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтүүдийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/*

*Санхүүгийн байдлын үзүүлэлт*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| Хөрөнгө | | |
| Эргэлтийн хөрөнгө | 414,667,854,000 | 435,665,157,513 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 717,682,914,000 | 742,330,954,351 |
| **Нийт хөрөнгө** | **1,132,350,768,000** | **1,177,996,111,865** |
| Өр төлбөр ба эздийн өмч | | |
| Богино хугацаат өр төлбөр | 93,098,212,000 | 98,621,945,855 |
| Урт хугацаат өр төлбөр | 196,960,535,000 | 201,092,495,448 |
| Эздийн өмч | 842,292,021,000 | 878,281,670,561 |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **1,132,350,768,000** | **1,177,996,111,865** |

*Орлогын тайлан*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| Борлуулалтын орлого (цэвэр) | 1,320,663,900,000 | 667,120,808,328 |
| Борлуулалтын өртөг | (748,938,545,000) | (384,553,376,130) |
| Нийт ашиг ( алдагдал) | **571,725,355,000** | **282,567,432,198** |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **253,974,906,433** | **136,569,344,245** |
| Орлогын татварын зардал | (46,117,497,000) | (31,769,968,687) |
| **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | **207,857,409,433** | **104,799,375,558** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 747,472,000 | 1,107,933,791 |
| **Нийт орлогын дүн** | **208,604,881,433** | **105,907,309,349** |
| Толгой компанийн хувьцаа эзэмшигчэд ноогдох | 208,604,881,433 | 105,907,309,349 |
| Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох | - | - |

| | | |
|---|---|---|
| | *Өмчийн өөрчлөлтийн тайлан* | (see table below) |

| | - | - |
|---|---|---|
| **Үзүүлэлт** | **Эхний үлдэгдэл** | **Эцсийн үлдэгдэл** |
| Өмч | 106,418,200 | 106,418,200 |
| Халаасны хувьцаа | - | - |
| Нэмж төлөгдсөн капитал | 226,646,951,800 | 226,646,951,296 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 155,109,751,000 | 154,430,705,950 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | 745,860,000 | 1,107,933,791 |
| Хуримтлагдсан ашиг | 459,683,040,000 | 495,989,661,324 |
| **Нийт эздийн өмчийн дүн** | **842,292,021,000** | **878,281,670,561** |
| Хяналтын бус хувь оролцоо | - | - |
| **Нийт дүн** | **842,292,021,000** | **878,281,670,561** |

*Мөнгөн гүйлгээний тайлан*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 272,298,611,109 | 153,363,600,986 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (196,018,554,512) | (76,335,028,544) |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (46,146,672,013) | (77,996,801,285) |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **30,133,384,584** | **(968,228,842)** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 78,539,186,008 | 108,972,079,584 |
| Мөнгөн хөрөнгийн үнэ цэнийн бууралт болон валютын ханшийн өөрчлөлт | 299,509,000 | - |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **108,972,079,592** | **108,003,850,742** |

2. *Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт*

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 сарын 18-ны өдрийн ээлжит хурлаар АПУ Групп компанийн 2026 оны 1 дүгээр хагас жилийн тайланг хэлэлцэн батална.

3. *Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт*

3.1. *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/*

| Харьцаанууд | 2025 | 2026Q2 |
|---|---|---|
| Нийт ашгийн хувь | 43% | 42% |
| Үйл ажиллагааны ашгийн хувь | 19% | 20% |
| Цэвэр ашгийн хувь | 16% | 16% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | 25% | 12% |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг | 195.32 | 98.48 |

3.2. *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт*

| Харьцаанууд | 2025 | 2026Q2 |
|---|---|---|
| Эргэлтийн харьцаа | 4.45 | 4.42 |
| Түргэн хөрвөх чадварын харьцаа | 2.58 | 2.67 |
| Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа | 0.34 | 0.34 |

3.3. *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл*

- 2026 оны эхний хагас жилийн байдлаар дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал, геополитикийн эрсдэл, түүхий эд, шатахууны үнийн хэлбэлзэл нь бизнесийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн хэвээр байна.
- Согтууруулах ундааны зах зээлд хэрэглэгчдийн худалдан авалтын чиг хандлага импортын бүтээгдэхүүн рүү шилжиж буйтай холбогдон дотоодын өрсөлдөөн нэмэгдсээр байна.
- Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлд эзлэх хувийг өсгөх зорилгоор нэмэлт санхүүжилт татан төвлөрүүлж, үйлдвэрлэл болон дэд бүтцийн хөрөнгө оруулалтуудыг шат дараатайгаар хэрэгжүүлж байна.
- Бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн хэрэгцээг илүү өргөн хүрээнд хангах зорилгоор сүү, сүүн бүтээгдэхүүний брэнд болон нэр төрлийг нэмэгдүүлэн, тасралтгүй хөгжүүлж ажилласан.

| | | |
|---|---|---|
| *3.4.* | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэсдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого* | Балансын гадуурх ажил гүйлгээ байхгүй болно. |
| *4.* | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/* | |
| | - Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй<br>- Сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээг жилийн эцсийн тайлангаар толилуулна. | |
| *5.* | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл* | |
| | Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй. | |
| *6.* | *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл* | |

**Хувьцаа эзэмшигчдийн хурал**

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр 2026 оны 04 сарын 22-ны өдрийн 14:00-15:15 цагийн хооронд 87.95%-ийн ирцтэй хуралдаж дараах шийдвэрийг гаргав:

1. АПУ ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан “АПУ групп компани 2025 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан” гэсэн дүгнэлтийг батлав.
2. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгов.
3. АПУ ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр П.Батсайхан, Б.Батбаяр, Кеннет Чу, **Шелли Коли**, Б.Гантиг, Б.Гомбо-Эрдэнэ нарыг, хараат бус гишүүнээр Ё.Гэрэлчулуун, О.Одбаяр, Ж.Үнэнбат нарыг 3 жилийн хугацаагаар сонгов.
4. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг ТУЗ-ийн дарга 10 сая, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая байхаар батлав.

**Төлөөлөн удирдах зөвлөл**

Хувьцаа эзэмшигч Хайнекен Азиа Пасифик Пте.Лтд компаниас ТУЗ-ийн ердийн гишүүн Сэн И-Ингийн оронд Шелли Колиг нэр дэвшүүлсний дагуу хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлаар ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан сонгосон.

| ТУЗ-ийн өмнөх гишүүн | ТУЗ-ийн шинэ гишүүн |
|---|---|
| ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн аудитын хорооны гишүүн<br>**СЭН И-ИН**<br>**Хуульч мэргэжилтэй**<br>2020-2026 онд Хайнекен Азиа Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийн Хууль эрхзүй хариуцсан захирал<br>2020-2026 онд АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн  | ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн аудитын хорооны гишүүн<br>**ШЕЛЛИ КОЛИ**<br>**Хуульч, эдийн засагч, улс төр судлаач мэргэжилтэй**<br>2026 оноос Хайнекен Азиа Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийн Хууль эрхзүй хариуцсан захирал<br>2026 оноос АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн<br>Хувьцаа эзэмшил: Хувь хүн: 0 ширхэг (0.00%)<br>Хайнекен Азиа Пасифик Пте Лтд: 266,091,981 ширхэг (25.00%)  |

**ТУЗ-ийн дэргэдэх хороод**

Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлаар сонгосон ТУЗ-ийн бүрэлдэхүүн 2026 оны 05

сарын 05-ны өдрийн хурлаар ТУЗ-ийн даргаар П.Батсайханыг улираан сонгож, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүнээр Шелли Колиг шинээр томилов. Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хороодын бүрэлдэхүүнийг өөрчлөлтгүйгээр баталсан болно.

**Гүйцэтгэх удирдлагын баг**

Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, гүйцэтгэх дэд удирдлагын багийг удирдан ажилладаг. Гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.

| **Гүйцэтгэх дэд удирдлагын багийн бүрэлдэхүүн:** | | | |
|---|---|---|---|
| Гүйцэтгэх захирал<br>**ЦЭВЭЭНЖАВЫН ЭРДЭНЭБИЛЭГ** |  | | |
| Санхүү эрхэлсэн захирал<br>**ГОНЧИГИЙН ЭНХБИЛЭГ** |  | Хүний нөөц эрхэлсэн захирал<br>**ЖАРГАЛСАЙХАНЫ ИЧИНХОРЛОО** |  |
| Үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхэлсэн захирал<br>**ГЕОРГИЙ ГУБЕЛАДЗЕ** |  | Дижитал шилжилт, өөрчлөлт эрхэлсэн захирал<br>**АЛЛАН ОНГ** |  |
| Борлуулалт, маркетинг эрхэлсэн захирал<br>**БАТСАЙХАНЫ ЦАЦРАЛ** |  | АПУ Дэйри ХХК-ийн Гүйцэтгэх захирал<br>**ГАЛСУМЪЯАГИЙН БАЯРМАГНАЙ** |  |

**Бусад эрх бүхий албан тушаалтан**

Компанийн дүрэмд зааснаар ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдээс гадна ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Ерөнхий нягтлан бодогч нь компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно. Тайлант хугацаанд ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Базаррагчаагийн Сарантунгалаг, Ерөнхий нягтлан бодогчоор Батсуурийн Даваадорж ажиллав.

7. *Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл*

**Хувьцаа эзэмшигчдийн бүтэц**

АПУ ХК-ийн хувьцаа эзэмшигчид (2026 оны 04 сарын 02-ны өдрийн байдлаар)

| Д/д | Хувьцаа эзэмшигч | Хувьцааны тоо ширхэг | Эзэмшлийн хувь |
|---|---|---|---|
| 1 | ШУНХЛАЙ ХОЛДИНГ ХХК | 602,651,260 | 56.63 |
| 2 | HEINEKEN ASIA PACIFIC PTE LTD | 266,091,981 | 25.00 |
| 3 | STEPPE BEVERAGE KFT | 58,829,058 | 5.53 |
| 4 | Бусад | 136,609,254 | 12.84 |

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь хэмжээнд өөрчлөлт гараагүй.

**Ногдол ашгийн мэдээлэл**

ТУЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 26/02 тоот тогтоолоор 2025 оны хоёрдугаар хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан нэгж хувьцаанд 65 (жаран тав) төг, нийт 69,171,800,945 (жаран есөн тэрбум нэг зуун далан нэгэн сая найман зуун мянга есөн зуун дөчин тав) төг-ийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэн, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр буюу 2026 оны 04 сарын 02-ны өдрөөр тогтоов.
Ийнхүү 2025 оны эхний ба сүүлийн хагас жилийн нийлбэр дүнгээр нэгж хувьцаанд 130 төг-ийн ногдол ашиг хуваариллаа.
Тус ногдол ашгийн төлбөрийг нийт хувьцааны тавaас доош хувийг эзэмшигчдэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршуулсан ба тавaас дээш хувийг эзэмшигчдэд хүсэлтийн дагуу компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгов.

**Хувьцааны мэдээлэл**

АПУ ХК-ийн хувьцааны хаалтын ханш тайлант хугацааны туршид харьцангуй тогтвортой байж, ₮989.2 төгрөгөөс ₮969.22 төгрөгийн хооронд хэлбэлзэв. Зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үетэй адил 1.03 их наяд төгрөг байснаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудаас дөрөвдүгээр байранд жагслаа.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ц.Эрдэнэбилэг

Албан тушаал: “АПУ” ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: ………………………………………..

*(Тамга/тэмдэг)*

МОНГОЛ УЛС
APU COMPANY
Absolute. Pure. Unique.
АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ
2702673 1116224357

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Сарантунгалаг

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: ………………………………………..